ШУА-ХХТХ-ийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл

2026.06.03 № *3* Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны хурал 2026 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 11 цагт цахим ба танхимаар хуралдав.

Хурлын бүрэлдэхүүнд:

1. Л.Мандахсайхан /МСТЛ-ийн ЭШДэА/
2. О.Хүрэлдаваа /ХБОХЛ-ийн ЭШАА /
3. Г.Жаргалан /УХТЛ ЭШДаА/
4. Н.Батжаргал /"Худалдан авах үйл ажиллагааны хөтөч" ТББ-ын төлөөлөл/
5. П.Гантуяа /"Худалдан авах үйл ажиллагааны хөтөч" ТББ-ын төлөөлөл/

Ирц 100% байв.

Хэлэлцэх асуудал: "***Рентген флюоресценцийн спектрометр (X-ray Fluorescence Spectrometer) багаж худалдан авах***" ХХТХН/20260102001 дугаартай тендерийг дахин зарласан ба ирүүлсэн материалуудад үнэлгээ хийх, үнэлгээний хорооны дүгнэлтийг гаргаж ХХТХ-ийн захиралд танилцуулах.

Хэлэлцсэн нь:

Г.Жаргалан: ШУА-ийн ХХТХ-ээс зарласан "***Рентген флюоресценцийн спектрометр (X-ray Fluorescence Spectrometer) багаж худалдан авах",*** ХХТХН/20260102001 тоот дахин зарласан нээлттэй тендер шалгаруулалтад нийт 3 компани үнийн санал, тендерийн баримт бичиг бүрдүүлэн ирүүлсэн байна. "**СИ АЙ ТИ**" (SHIMADZU EDX-8100) 504.000.000, "**МАСС ТЕЧ**" (RIGAKU NEX DE) 491,460,200, "**МЕДМОНГОЛ**" (JEOL JSX-1000S) 476,899,500 гэсэн багажуудыг дээрх үнээр нийлүүлэхээр санал болгосон байна. Ирүүлсэн компаний материалтай манай үнэлгээний хорооны гишүүд болон захиалагч талын мэргэжилтэн танилцан өөрсдийн үнэлгээ, саналыг ирүүлсэн. Үнэлгээний хороодын гишүүд өөр өөрийн саналыг гаргасан байна.

О.Хүрэлдаваа: Тендерт ирүүлсэн материалуудтай танилцахад "Масс Теч" дистрибьютер баталгаа, ижил төстэй бараа нийлүүлсэн материал байхгүй, ""Масс Теч" ба "Медмонгол" сургалтын талаарх мэдээлэл ирүүлээгүй харагдаж байна.

Г.Жаргалан: 2024, 2025 оны байдлаар харахад 3 компань нь аль нэг жилд борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 50%-иас багагүй байна гэсэн шалгуурыг хангаж байна. Хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй болохыг баталж байна. Тендерийн баталгааг 3 компань гаргасан байна. Мед Монгол ХХК болон Си Ай Ти ХХК нь Эм эмнэлгийн хэрэгсэл/лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүн/импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Мед Монгол ХХК болон Си Ай Ти ХХК нь ижил төстэй тендерийн

CamScanner

мэдээлэл ирүүлсэн. Си Ай Ти ХХК нь Shimatzu компанийн албан ёсны дистрибютер компань юм.

Л.Мандахсайхан: Оролцогч 3 компаниас ирүүлсэн техникийн тодорхойлолтын харьцуулсан хүснэгтийг захиалагч талд илгээсэн бөгөөд захиалагч тал үүнтэй танилцаж өөрийн саналыг ирүүлсэн байгаа. Үүнийг нарийн бичгийн дарга Жаргалан танилцуулна.

Г.Жаргалан: Захиалагч талаас ирүүлсэн техникийн тодорхойлолтын харьцуулсан хүснэгт дээр техникийн үзүүлэлтийн шаардлага хангасан эсэхийг хүсгнэгтээр ирүүлсэн. Мөн тайлбар хэсэгт техникийн тодорхойлолтын ерөнхий дүгнэлтийг ирүүлсэн байна. Үүнийг уншиж танилцуулбал:

"Хими, химийн технологийн хүрээлэнгээс зарласан ХХТХН/20260102001 дугаартай Рентген флюоресценцийн спектрометр (XRF) багаж худалдан авах тендерт оролцох сонирхолоор ирүүлсэн "СИ-АЙ-ТИ" ХХК, "МАСС ТЕЧ" ХХК, "МЕД МОНГОЛ" ХХК гэсэн 3 компаний Shimadzu Corp, EDXRF EDX-8100; Rigaku Corp, EDXRF Nex De Series; JEOL Ltd. Japan, EDXRF JSX-1000S гэсэн 3 төрлийн Энергийн дисперсийн рентген флюоресценцийн спектрометр (Energy Dispersive X-ray Fluorescence Spectrometry - EDXRF)-ийн үзүүлэлтийг тус тендерийн техникийн тодорхойлолттой нийцэж байгааг хянан үзээд;

"СИ-АЙ-ТИ" ХХК-ийн санал болгосон Shimadzu Corp, EDXRF EDX-8100 загварын EDXRF нь техникийн тодорхойлолттой нийцэж байна гэж үзэж, ус тендерт шалгаруулах саналтай байна.

"МАСС ТЕЧ" ХХК-ийн санал болгосон Rigaku Corp, EDXRF Nex De Series загварын EDXRF нь үнийн хувьд "СИ-АЙ-ТИ" ХХК-ийн санал болгосон Shimadzu Corp, EDXRF EDX-8100 загварын EDXRF-ээс 27,100,500 төгрөгөөр хямд боловч техникийн тодорхойлолтод байгаа нунтаг дээж пресслэгч болон шилэн дээж бэлтгэх төхөөрөмжүүд нийлүүлэлт ороогүй, мөн элементийн хамрах хүрээ, рентген хоолойн материал, генераторын чадал, анхдагч фильтер байрлал болон детектор сисмемийн тооллогын хурд нь тус тендерийн техникийн тодорхойлолтод нийцэхгүй байна.

"МЕД МОНГОЛ" ХХК-ийн санал болгосон JEOL Ltd. Japan, EDXRF JSX-1000S загварын EDXRF нь үнийн хувьд "СИ-АЙ-ТИ" ХХК-ийн санал болгосон Shimadzu Corp, EDXRF EDX-8100 загварын EDXRF-ээс 12,539,800 төгрөгөөр хямд боловч техникийн тодорхойлолтод байгаа элементийн хамрах хүрээ, Камерын орчин, Цацрагийн талбай, анхдагч фильтер байрлал, детектор сисмемийн тооллогын хурд болон хэмжилтийн орчин зэрэг нь тус тендерийн техникийн тодорхойлолтод нийцэхгүй байна." гэсэн саналыг ирүүлсэн байна.

Л.Мандахсайхан: Захиалагч талын ирүүлсэн саналаас үзэхэд "МАСС ТЕЧ" ба "МЕД МОНГОЛ"-с ирүүлсэн багажны техникийн үзүүлэлт бидний шаардсан үзүүлэлтийг зарим нэг талаараа хангахгүй байна гэж үзэхээр байна.

Н.Батжаргал: Нэгэнт дээрх 2 компаниас санал болгосон багажийн техник үзүүлэлт шаардлага хангахгүй байгаа бол шаардлага хангаж байгаа СИ-АЙ-ТИ" ХХК-ийн санал болгосон Shimadzu Corp, EDXRF EDX-8100 загварын EDXRF багажийг шаардлага хангасан гэж үзээд шалгаруулах саналтай байна.

CamScanner

П.Гантуяа: Хэдийгээр "МАСС ТЕЧ" ба "МЕД МОНГОЛ"-с санал болгосон багажны үнийн санал нь бага байгаа боловч техникийн шаарлага хангахгүй байгаа нь тендерээс хасагдах шалтгаан мөн юм.

О.Хүрэлдаваа: Санал нэг байна.

Л.Мандахсайхан: Бид ШУА-н ХХТХ-с зарласан "***Рентген флюоресценцийн спектрометр (X-ray Fluorescence Spectrometer) багаж худалдан авах***" ХХТХН/20260102001 дугаартай худалдан авах ажиллагаанд ирүүлсэн 3 компанийн материалтай дор бүрнээ танилцаж өөрсдийн шийдвэрээ гаргасан. Технизийн ба бусад шаардлагыг хангаж байгаа СИ-АЙ-ТИ" ХХК-ийн санал болгосон Shimadzu Corp, EDXRF EDX-8100 загварын EDXRF багажийг шалгаруулах нь зүйтэй хэмээн шийдвэрлэж, дүгнэлтийг хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайханд хүргүүлэхээр шийдвэрлэх саналыг хураая.

П.Гантуяа: Дэмжиж байна.

О.Хүрэлдаваа: Дэмжиж байна.

Н.Батжаргал: Дэмжиж байна.

Г.Жаргалан: Дэмжиж байна.

Л.Мандахсайхан: СИ-АЙ-ТИ" ХХК-ийн санал болгосон Shimadzu Corp, EDXRF EDX-8100 загварын EDXRF багажийг шгалгаруулах эсэх дээр санал хураахад 100 хувийн саналаар дэмжсэн байна. Үнэлгээний хорооны хурлын шийдвэрийг ХХТХ-н захиралд, оролцогч байгууллагуудад мэдэгдэл хүргүүлэх ажлыг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Г.Жаргаланд даалгаж байна.

Протокол хөтөлсөн: Г.Жаргалан

Протоколтой танилцсан: Л.Мандахсайхан
О.Хүрэлдаваа
Н.Батжаргал
П.Гантуяа

CamScanner